



МОНГОЛ УЛС  
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 04 сарын 04 өдөр

Дугаар А/238

Номгон

Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл  
ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлд  
хаягийн өөрчлөлт хийх тухай


Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5 а, Эрүүл мэндийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1 дэх заалт, Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн комиссын 2021 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1."Монос-Баянхонгор" ХХК-ний 3136574 регистрийн дугаартай "Монос" ЭСХ-20/03/001 дугаартай нэгдүгээр зэрэглэлийн эмийн сангийн тусгай зөвшөөрлийн хаягийг Баянхонгор сумын 10 дугаар багийн НААҮ-ний баруун урд хэсэг "Тумбааш төв"-ийн байранд шилжүүлсүгэй.

2.Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн газар, Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн комиссын дарга (Н.Энхжаргал), Мэргэжлийн хяналтын газар (Н.Бямбадорж) нарт тус тус үүрэг болгосугай.

3.Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс (Д.Энхжаргал)-т даалгасугай.

ДАРГА



Д.МӨНХСАЙХАН

1110597